

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг. Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;²
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;³
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁴
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁵
-

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх этгээдэд үүсэх зардал, ачааллыг тооцох зорилгоор хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлоход иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэх

¹ Хууль тогтоомжийн тухай <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

³ Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

⁴ Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

⁵ Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

зохицуулалт тусгагдаагүй тул хуулийн хэрэгжилтэд аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

Харин тус хуулийн төсөлд төрийн байгууллага буюу татварын албаны хэрэгжүүлэх нэмэлт чиг үүргийг тодорхойлон тусгасан тул зардал тооцох шаардлагатай зохицуулалтуудыг түүвэрлэн, аргачлалын дагуу зардал тооцсон болно.

Хоёр. ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Аргачлалын 4.1-д зааснаар Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 4.2.уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гарах зардлыг урьдчилан тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулахаар тогтоосон.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслөөс үнэлгээ хийх зохицуулалтыг сонгохдоо хэрэгжүүлэх чиг үүрэг, хэмжих боломжтой ажил, үйлчилгээг тусгасан зохицуулалтыг сонголоо. Үүнд, хуулийн төсөл батлагдсанаар тодорхой төрийн байгууллага, субъектэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсхүл тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж бий болгох шаардлагатай эсэх зэрэг зардал үүсгэж болохуйц зохицуулалтууд хамаарна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хуулийн төслийн 2, 3 дугаар зүйлд заасан өөрчлөлтүүд нь улсын төсөвт зардал үүсэх боломжтой, татварын албаны гүйцэтгэх чиг үүрэг /ажил, үйлчилгээ/-т хамаарах зохицуулалт ба тухайн чиг үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааг доор тодруулав.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Хэрэгжүүлэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа
Хуульд оруулсан өөрчлөлтийн хэсэг		
Чиг үүрэг-1 23.1.1. албан татвар төлөгчийн 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах жилийн албан татварыг 100 хувиар хөнгөлнө. 23.1.2. энэ хуулийн 23.1.1-д заасан хөнгөлөлтийн хэмжээ тухайн татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлогын 90 хувиас хэтрэхгүй бөгөөд 960,000 төгрөг хүртэл байна”	Татварын алба	Татвар төлөгчид эдлүүлэх хөнгөлөлтийг суутган төлөгч тодорхойлж ногдуулдаг байсан бол татварын алба тухайн татвар төлөгчийн эдлэх хөнгөлөлтийн тооцооллыг хийнэ;
Чиг үүрэг-2 23.3. Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авах, барих, орон сууцны	Татварын алба	Албан татвар төлөгчийн эдлэх хөнгөлөлтийг төрөл тус бүрээр тооцооллыг нягтлах; (<i>улирал тутам</i>)

нөхцөл сайжруулахад зарцуулсан төлбөрийн баримтаар нотлогдох дараах зардалтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг тухайн татвар төлөгчид нэг удаа эдлүүлэх бөгөөд хөнгөлөлтийн дүн заалт тус бүр 15 сая төгрөг хүртэл байна.		
Чиг үүрэг-3 26.1. Татвар төлөгчийн албан татварыг тодорхойлох, ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор татварын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан боловсруулж, цахим татварын системээр татвар төлөгчид хүргүүлэх үйлчилгээ үзүүлнэ.	Татварын алба	ТБМНС-н мэдээллийн дагуу албан татвар төлөгч тус бүрээр албан татвар ногдох орлого, ногдуулах орлого, төлөх албан татварын хэмжээг нэг бүрчлэн тодорхойлж татвар төлөгчид цахимаар хүргүүлнэ. <i>(улирал тутам)</i>
Чиг үүрэг-4 26.8. Татвар төлөгч энэ хуулийн 26.7-д заасан хугацаанд тайлангийн төслийг хянаж баталгаажуулаагүй бол энэ хуулийн 23.1-д заасан татварын хөнгөлөлтийг хасаж эцсийн төлбөл зохих татварыг тооцно.	Татварын алба	Татвар төлөгчид хүргүүлсэн тайланг татвар төлөгчөөс хянаж баталгаажуулсан эсэх, өөрчилж тайлагнасан тайланг нягталж эцсийн төлбөл зохих татварыг тооцоолно. <i>(улирал тутам)</i>
Чиг үүрэг-5 28.4. Энэ хуулийн 28.3-т заасан албан татвар төлөгчийн буцаан авах, илүү төлсөн албан татварыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан дараах хугацаанд буцаан олгоно 28.4.1. энэ хуулийн 28.1.2-т заасан буцаан олголтыг татвар төлөгч тайлангаа тушаасан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан;	Татварын алба	Албан татвар төлөгчийн хянаж баталгаажуулсан тайлангийн буцаан авах 23.1 дэх хэсэгт заасан хөнгөлөлтийг тайлан баталгаажуулснаас хойш ажлын 15 хоногт багтаан буцаан олголтыг олгох ажлыг зохион байгуулна.
Чиг үүрэг- 6 Татварын ерөнхий хуулийн 75.1.1. татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах;	Татварын алба	Татвар төлөгчид хүргүүлэх мэдээлэл, зөвлөгөөг боловсруулах Татварын албаны үйл ажиллагаанд ашиглах ТБМНС-н мэдээллийг өргөжүүлэх Татвар төлөгчид мэдээлэл зөвлөгөө хүргүүлэх.

2.1. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслийн 2 болон 3 дугаар зүйлд заасан чиг үүргийг өмнө албан татвар төлөгчид орлого олгож буй этгээд суутган авч хөнгөлөлтийг тооцоолдог байсан бол уг чиг үүрэг татварын албанд шинээр үүрэг үүсгэсэн зохицуулалт гэж үзэх үндэслэлтэй байна.

Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд 231 татварын улсын байцаагч, орон нутагт 462 татварын улсын байцаагч нийт 693 татварын улсын байцаагч Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хувь хүний орлогын албан татварын тайланг татварын албанаас хүргүүлэх давтамжийг улиралд нэг байхаар тусгасан бөгөөд татвар төлөгчийн албан татварыг тодорхойлох, ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор татварын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан боловсруулж, цахим татварын системээр татвар төлөгчид хүргүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

Татварын албанаас албан татвар төлөгч нэг бүрийн тайланг хүлээн авч хянан баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн ч хуулийн өөрчлөлтөөр татвар төлөгч нэг бүрийн тайланг татварын албанаас урьдчилан боловсруулж хүргүүлэх, татвар төлөгч тайлангаа хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй тохиолдолд өөрт байгаа мэдээлэлд үндэслэн татварын ногдлыг тодорхойлох чиг үүрэг шинээр орж ирсэн, Монгол улсын засгийн газраас төрийн албан хаагчийн орон тоог нэмэгдүүлэхгүй гэсэн бодлого барьж байгаа тул уг чиг үүргийн хүрээнд нэмэлт зардал гаргахгүйгээр системийн түвшинд тооцооллыг хянах зохион байгуулалтыг хийнэ.

Тодруулбал: Хуулийн төслийн нэмэлт өөрчлөлтөөр оруулж буй зохицуулалтыг Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, ХҮР, ДАН систем дэх мэдээллийг ашиглан тооцоолох, татвар төлөгчид татварын албаны Е-TAX системээр дамжуулан цахимаар татвар төлөгчид хүргүүлнэ.

2.2. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Татварын алба хуулийг хэрэгжүүлэхдээ хүний нөөцийн дотоод зохион байгуулалт хийж, бусад материаллаг зардлыг нэмэхгүй одоогийн хэмжээнд барьж ажиллах юм. Хуулийн төслийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны 1-5 дахь чиг үүргийг татварын алба хүний нөөцийн боломжоор шийдвэрлэх ба 6 дахь чиг үүргийг хэрэгжүүлэхэд хуульд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор нэмэлт зардал үүсэхээр байна.

2.2.1. Хүний нөөцийн цалин, материаллаг зардал:

а/ Татварын улсын байцаагчийг төрийн албан хаагчийн ТЗ-7 зэрэглэлийн шатлалаар цалинжуулж, бусад нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийг төр хариуцна гэж үзвэл нэг татварын улсын байцаагчийн цалин, хөдөлмөрийн хөлсний зардалд жилд дунджаар 1,539,000 сая төгрөг, бөгөөд нэмэгдэл, урамшуулал цалин хөлс орсон дүнгээр 26,386,155 төгрөг зарцуулахаар байна.

Нэг ажилтны цалингийн зардлыг татварын албанд мөрдөж буй цалингийн сүлжээ, хувь хэмжээг баримтлан тоймлон тооцоход дараах дүн гарч байна. Ажилтны цалин болон орон тоог 2024 оны гүйцэтгэлээр авсан болно. Үүнд:

Өгөгдийн нэр	Нэмэлт нөхцөл	Дүн /төг/
Үндсэн цалин /ТЗ-7/ шатлалаар		1 539 000.00
Удаан жилийн нэмэгдэл /11-15 жил ажилласан гэж тооцож/	10 хувь	153 900.00
Зэрэг дэвийн нэмэгдэл /гутгаар зэргийн дэс түшмэл/	17 хувь	261 630.00
Жилийн тооцоолол	12 сар	$(1539000+153900+261630)*12=23\,454\,360.00$
Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл /нийлбэр дүнгээр/	12.5 хувь гэж тооцов	2 931 795.00
Цалинтай холбоотой нийт зардал /жилийн цалин/		26 386 155.00

б/ материаллаг зардал

Татварын алба 2024 онд 1,834 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгө оруулалтын нийт 4,527,541.30 сая төгрөгийн зардал гарсан байна.

Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг тооцож үзвэл:

4,527,541.30 сая ₮ /1834 = **2,468,670 төгрөг**

Хувь хүний орлогын татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах албан хаагчид ногдох материаллаг зардлыг тооцож үзвэл:

$2,468,670.0₮*693=1,710,788,310$ төг

-Бусад зардал

Татварын албаны жилийн төсөвт зардлаас цалин хөдөлбөрийн хөлстэй холбоотой зардлыг цалингийн зардал хэсэгт, үлдэх зардлыг материаллаг зардал тооцоход хамруулан тооцсон тул хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт зардлаас илүү гарах бусад зардал гарахгүй болно.

Нэг албан хаагчийн зардал **28,854,825 төгрөг, 693 албан хаагч гэж үзвэл 693 албан хаагчид 19,996.4 сая төгрөгийн зардал гарахаар байна.**

2.2.2. Хууль сурталчлах зардал:

а/ Монголын татварын алба нь боловсруулсан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайль үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн татварын албанаас тооцоолох албан татварын хөнгөлөлтийн тооцоо, албан татвар төлөгчийн тайланг баталгаажуулахтай холбоотой мэдээ мэдээллийг бэлтгэх, түгээх үйл ажиллагааг зорилтот бүлэг буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ⁶чиглэсэн сургалт сурталчилгаа зохион байгуулах, мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй холбоотой дараах зардал зайлшгүй гарахаар байна. Үүнд:

⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 4.1.1 “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг”

- Сонсголгүй иргэдэд зориулсан дохионы хэлмэрчийн орчуулга бүхий видео контент бэлтгэх, түгээх зардал; (Жилдээ)
- Харааны бэрхшээлтэй иргэдийн цахимаар тайланг баталгаажуулахтай холбоотой “брайль үсэг” бүхий зөвлөгөө мэдээлэл бүхий гарын авлага, сургалтын материал боловсруулах зардал; (Жилдээ)

Татварын албанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах дагалдан гарах бусад зардлыг тооцоолов.

Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн санд⁷ 2024 оны байдлаар улсын хэмжээнд 11,498 харааны бэрхшээлтэй иргэд байна. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан жилд 4 төрлийн гарын авлага, зөвлөмж, сургалтын материалыг бэлтгэхэд нэг мэдээлэлд 3 хуудас гэж тооцоолоход нийт 137,976 хуудас бүхий мэдээллийг татварын алба олон нийтэд түгээхээр байна. Брайль үсэг хэвлэлийн үйлдвэр нь 1 нүүр мэдээллийг /760 орчим тэмдэгт багтсан/ хэвлэхэд 2500 төгрөгийг зарцуулна гэж тооцвол нийт **344.9 сая төгрөгийн зардал** гарахаар байна.

Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн санд⁸ 2024 оны байдлаар улсын хэмжээнд 7,561 сонсголын бэрхшээлтэй иргэд байна. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг дүрс бичлэг байдлаар түгээх учир татвар төлөгчийн тооноос хамааралгүй тул ойролцоогоор 4 төрлийн зөвлөмж, гарын авлага, холбогдох материалыг 200 мин орчим дүрс бичлэг, дохионы хэл рүү хэлмэрчлэхэд 1 цаг 70,000 төгрөгийн зардал гарна гэж тооцвол нийт 300,000 төгрөгийн зардал гарахаар байна. 3 цагийн сургалтын үйл ажиллагааг хэлмэрчлэхэд 165,000 төгрөг гэж тооцвол жилд 32 удаа (татварын албаар тооцоолов) сургалт зохион байгуулахад нийт зардал нь **5.3 сая төгрөгийн зардал** гарахаар байна.

б/ Татварын хуулийн өөрчлөлтөөр Татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан боловсруулж, цахим татварын системээр татвар төлөгчид хүргүүлэх үйлчилгээ үзүүлэх, албан татвар төлөгч тухайн жилийн тайлангийн төслийг дараа оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хянан баталгаажуулснаар татварын тайлан тушаасанд тооцно, гэж татвар эдийн засгийн харилцаанд орсон иргэн бүр татварын тайлан гаргаж татварын хөнгөлөлт эдлэхээр зохицуулагдсан тул хуулийн сурталчилгааны зардал нэмэлтээр гарах шаардлага үүснэ. Татвар төлөгчийн сургалт, цахим маркетинг, контент, гарын авлага, бусад хэвлэмэл материалын зардалд нийт **554.0 сая төгрөгийн зардал** гарах тооцлоо.

Монголын татварын алба хуулийн төслийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбоотой заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд дунджаар **560.0 сая** төгрөгийн зардал нэмэлтээр гарахаар байна.

Татварын албаны жилийн төсөвт зардлаас цалин хөдөлмөрийн хөлстэй холбоотой зардлыг цалингийн зардал хэсэгт, үлдэх зардлыг материаллаг зардал тооцоход хамруулан тооцсон тул хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах мэдээлэл сурталчилгаа хийх зардал гарахаар тооцоолов.

⁷ [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан](#)

⁸ [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан](#)

2.3. Үр дүнг тооцох

Хуулийн төслийн зардлын тооцоо хийсэн зохицуулалт нь Татварын албанд үүрэг үүсгэсэн ба үүнтэй холбогдон хэрэгжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагаа нэмэлтээр хүний нөөцийн зардал гарахгүй, хүний нөөцийн зардалтай уялдах материаллаг зардал шаардагдахгүй гэж тооцоолов.

/сая төгрөгөөр/

Зардлын нэгтгэл	Шаардагдах зардал	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт
Хүний нөөцийн цалин, материаллаг зардал	28.8	693	19,958.4
Хууль сурталчлах зардал /нэмэлтээр/	560.0	1	560.0
НИЙТ /жилээр/			20,518.4

2.4. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувь хүний орлого, үйл ажиллагааны онцлог шинж чанартай уялдуулан хялбаршуулсан горимоор тайлагнах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Үүнээс үүдэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх зардал одоогийн хэмжээнээс **350.2 сая төгрөгөөр нэмэгдэх тооцооллыг хийсэн.**

Гурав. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

1.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулийн төсөлд заасны дагуу хуулийн этгээд нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- хувь хүнд олгосон орлогоос албан татвар суутгаж, суутган тооцоололтой холбоотой тайлан, мэдээ, тодруулга гаргаж татварын албанд тушаах;
- хувь хүний орлогын албан татварыг төсөвт шилжүүлэх.

1.2.Зардлыг тооцох

Зардлыг тооцохдоо хуулийн этгээдийн 2024 онд татварын албанд хүргүүлсэн суутган тайлангийн үзүүлэлтэд үндэслэв. Нягтлан бодогч санхүү, татвар, нийгмийн даатгалын болон бусад тайлан гаргах сарын дундаж зардлыг **1,500,000** төгрөг байна гэж төсөөлөв. Ажиллах хугацааг энэ аргачлалын “хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвар”-т заасны дагуу дор үзүүлсэн хүснэгтээр тооцон үзэхэд дараах байдалтай байна:

№	Ерөнхий үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)		
		Энгийн	Дунд	Бүрэн
1	Үүрэгтэй танилцах, судлах	10	15	20
2	Мэдээлэл цуглуулах	10	15	20
3	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	30	40	60

4	Тооцоо хийх /ажилчдын цалингийн тооцоо/	30	45	60
5	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	20	30	45
6	Алдааг засах	20	30	45
7	Тоо баримтыг боловсруулах	10	15	20
8	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	3	5	10
9	Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	-	-	-
10	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	-	-	-
11	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	2	2	2
12	Олшруулах, архивлах, тараах	-	-	-
13	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	5	5	5
14	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	-	-	-
15	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	-	-	-
16	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	-	-	-
	Нийт	140	202	287

Сард 168 ажлын цаг, улиралд 504 ажлын цаг байна гэж үзэж (тайланг улиралд нэг удаа татварын албанд хүргүүлнэ), холбогдох тооцоог хийв.

Ажлын хөлс нэг цагт = $1,500,000/168 = 8,928.57$ төгрөг

Зардал (тус бүрийн)=Хугацаа × Ажлын хөлс = $8,928.57 * 2.33\text{цаг} = 20,803.57$ төгрөг болно.

1.3.Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт = тохиолдлын тоо * давтамжийн тоо

Тохиолдлын тоо = 178,411 (ирүүлсэн суутган тайлан) * 4 (улирал бүр) = 713,644

1.4.Нийт зардлыг тооцох

Нийт зардал = зардал * тоон үзүүлэлт = $20,803.57 \text{ төгрөг} * 713,644 = 14.8$ тэрбум төгрөг (жилд)

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд хуулийн этгээд нь хувь хүнд олгосон орлогод холбогдох татварыг суутган, төсөвт шилжүүлэх үүргийг хүлээж, тайлан гаргадаг. Иймээс хууль батлагдсанаар хуулийн этгээдийн хууль дагаж мөрдөхөд зарцуулдаг зардал өнөөгийн хэмжээнээс нэмэгдэхгүй.

1.5.Хялбарчлах боломж

Хувь хүний орлогын албан татварын хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлтэй холбоотойгоор хуулийн этгээдийн зардлыг бууруулах боломжийг Аргачлалд заасны дагуу дараах шалгууруудаар тодорхойлж үзлээ. Үүнд:

- **Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:** Татварын ерөнхий хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатай хуулийн этгээдүүдийг бүрэн бүртгэж, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан үүргүүдийг хүлээлгэнэ. Иймээс хамрагдах хуулийн этгээдийн тоог бууруулах боломжгүй. Гэхдээ хуулийн этгээд нь хувь хүнд олгож буй орлогоос холбогдох татварыг суутгаж, тайлагнах тохиолдолд тухайн хувь хүн уг орлогод ногдуулан төлөх татварын тайлан, тооцоог татварын албатай хийх шаардлагагүй. Харин байгууллагын нягтлан бодогч ажилчдын цалин хөлснөөс тухайн иргэний ажилласан сартай харьцуулж, хөнгөлөлт эдлэх тооцооллыг хийдэг байсныг хуульд өөрчлөлт орж, иргэн өөрөө тайлагнах зохицуулалт оруулснаар суутган төлөгч хуулийн этгээдэд тодорхой хэмжээний ачаалал буурсан;
- **Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасны дагуу хувь хүнд орлого олгож буй суутган төлөгч тухайн хувь хүнд олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын мэдээллийг цахимаар, татварын албанд хүргүүлэх бөгөөд уг мэдээллийн агуулга давтамжийг бууруулах боломжгүй. Татварын алба хүргүүлэх татварын тайлан, түүнийг бэлтгэх зааврыг татвар төлөгчид чирэгдэл багатай байх урьдчилан бэлтгэж болно;
- **Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:** хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэх тухай Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгаагүй, харин зарим үүргийг бууруулсан;
- **Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар зохицуулсан суутган тайланг тайлагнах боломжтой бөгөөд 2024 оны байдлаар нийт суутган тайлан тушаасан хуулийн этгээдийн 100 хувь нь цахимаар тайлан тушаасан байна;
- **Мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:** Хуулийн этгээд хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгаж, төсөвт шилжүүлсэн тухай суутган тайланг зөвхөн харьяа татварын албанд хүргүүлнэ;
- **Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх:** Татварын алба татвар төлөгч хуулийн этгээдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг. Гэхдээ дээр дурдсанчлан татвар төлөгчид суутган тайланг цахимаар хүргүүлж хэвшсэн болно.

1.6.Нэмэлт зардлыг тооцох

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хуулийн этгээд нь хувь хүнд олгосон орлогод холбогдох татварыг суутган, төсөвт шилжүүлэх үүргийг хүлээж, тайлагнаж ирсэн. Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулж хуулийн этгээдийн татварын хууль тогтоомж дагаж, мөрдөхтэй холбоотой нэмэлт зардал гарахгүй.

ХОЁР. ИРГЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэний зардлын тооцоонд тухайн иргэний төсөвт төлөх албан татварыг оруулаагүй болно. Хувь хүний орлогын албан

татварын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэний зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хувь хүн дараах үүргийг гүйцэтгэнэ:

- санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрдүүлэх
- Татварын албанаас бэлтгэн хүргүүлсэн тайлангийн төслийг хянаж, хуульд заасан хугацаанд баталгаажуулах
- тайлангаар гарсан татварын ногдлыг төсөвт төлөх үүргийг гүйцэтгэнэ.

2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох

Зардлыг тооцохдоо иргэдийн татварын албанд хүргүүлсэн тайлангийн үзүүлэлтэд үндэслэж хийсэн бөгөөд дараах хугацааг зарцуулна гэж төсөөлөв.

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)		
		Энгийн	Дунд	Бүрэн
1	Үүрэгтэй танилцах	10	15	20
2	Мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас)	-	-	-
3	Мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг нэгтгэх	-	10	20
4	Цуглуулсан мэдээллээ боловсруулах (нягтлах, тооцоолох, шалгах гэх мэт)	10	10	20
5	Маягт бөглөх	2	2	5
6	Албан бичиг боловсруулах (захиа, факс, цахим шуудан гэх мэт)	-	-	-
7	Мэдээллээ холбогдох газарт илгээх	2	2	5
8	Төлбөр хийх	2	2	2
9	Баримт бичиг хуулбарлах үдэх, хадгалах	-	-	-
10	Төрийн эрх бүхий байгууллагаар шалгалт хийлгэх	-	-	-
11	Эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөх	-	-	-
	Нийт	26	41	72

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасны дагуу үйл ажиллагааны орлого болон бусад орлого олж буй хувь хүн жилд нэг удаа татварын албанаас хүргүүлсэн татварын тайлангийн төсөлтэй танилцан, шалгаж, баталгаажуулах үүрэгтэй

2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо

Үйл ажиллагааны орлого бүхий иргэд: $323,772 = 323,772$ (тайлангийн тоо) × 1 (давтамж)

Цалин хөлсний орлоготой иргэд: $978,483 = 978,483$ (тайлангийн тоо) × 1 (давтамж)

Нийт тайлан ирүүлэх иргэний тоо: $323,772+978,483=1,302,255$ иргэн

2.4.Нийт дүнг тооцож гаргах;

Ачаалал=Цаг хугацаа × Тоон үзүүлэлт

$5,643.1$ цаг = 26 минут × 1,302,255 тайлан

Нийт зардал= ачаалал × зардал = $1,302,255 \times 4,714.29$ (цагийн хөлсний өмнөх жишгийг баримтлав) = 6,1 тэрбум төгрөг

2.5.Хялбарчлах боломжийг шалгах

Хувь хүний гаргах зардлыг бууруулах боломжийг Аргачлалд заасны дагуу дараах шалгуураар тодорхойлов. Үүнд:

- **Хамрагдах иргэний тоог багасгах боломж байгаа эсэх:** Татварын тэгш шударга байдлын зарчмыг хангах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, хувь хүний татвар төлөх идэвхийг сайжруулах, татвар төлөгч өөрөө тайлагнасны тохиолдолд татварын хөнгөлөлтийг эдлүүлэх нь хуулийн төслийн үндсэн зарчмын нэг тул татварт хамрагдах иргэдийн тоог бууруулах боломжгүй;
- **Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:** үйл ажиллагаа эрхэлж буй, албан татвар ногдох орлого олсон хувь хүн жилд нэг удаа тайлан гаргах тул давтамжийн тоог багасгах боломжгүй. Харин жилийн 400.0 сая төгрөг буюу түүнээс бага борлуулалтын орлого олж буй хувь хүн хялбаршуулсан горимоор тайлан гаргах боломжтой тул иргэдийн төлөх татварын хувь хэмжээ буурах боломжтой;
- **Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд цалингийн орлоготой хувь хүний цалингаас ажил олгогч суутгах үүрэгтэй байсныг хувь хүн өөрөө тайлагнах үүрэг хүлээлгэсэн. Татварын албанаас тайлангийн төслийг бэлтгэн хүргүүлэх, татвар төлөгч хянан баталгаажуулах үүрэгтэй болсон;
- **Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Хувь хүний орлогын албан татварын тайланг татварын алба урьдчилан боловсруулж хүргүүлнэ. Өнгөрсөн 2024 оны байдлаар татварын албанд үйл ажиллагааны орлого бүхий 302,255 хувь хүн тайлан цахимаар ирүүлснийг хүлээн авсан;

2.6.Нэмэлт зардлыг тооцох

Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу жил бүр татварын тайлан гаргаж, харьяа татварын албанд хүргүүлдэг. Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд үйл ажиллагааны болон цалин хөлсний орлого бүхий иргэн тайлан ирүүлэхээр зохицуулсан, харин үүнтэй холбогдуулан нэмэлт зардал гарахгүй.

Дөрөв. Нэгдсэн дүгнэлт

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тодорхойлох, зардал бууруулж, ачааллыг багасгах хувилбарын талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ. Ингэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан тооцоолов.

4.1. Төрийн байгууллагад үүсэх зардлын тухайд

Хуулийн төслийн зардлын тооцоо хийсэн зохицуулалт нь Татварын албанд үүрэг үүсгэсэн ба үүнтэй холбогдон хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр зардлын тооцоог хийж, судалгааны тайланд тусгасан. Тухайлбал уг хуулийн төсөл батлагдсанаар хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд татварын албанд дараах хэмжээний зардал үүсэхээр байна.

Чиг үүрэг 1-ээс 5-д заасан үйл ажиллагаа нэмэлтээр хүний нөөцийн зардал гарахгүй, ачаалал нэмэгдэхгүй тул хүний нөөцийн зардалтай уялдах материаллаг зардал шаардагдахгүй гэж тооцоолов.

Харин чиг үүрэг 6-д заасан ажлыг хэрэгжүүлэх буюу тухайн чиг үүрэг, ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах бусад зардлыг бодитой, дундаж үзүүлэлтэд үндэслэн гаргасан.

Чиг үүрэг 6. Татварын албанаас боловсруулсан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайль үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд жилд дунджаар нийт 350.2 сая төгрөгийн зардал гарахаар тооцоолов.

4.2. Хуулийн этгээд болон иргэнд үүсэх зардлын тухайд

Хувь хүний орлого, үйл ажиллагааны онцлог шинж чанартай уялдуулан хялбаршуулсан горимоор тайлагнах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төсөлд иргэн бүр төлсөн татвараасаа хөнгөлөлт эдлэхийн тулд тайлан гаргах үүрэг нэмэгдсэн бөгөөд хуулийн этгээдэд нэмэлт үүрэг бий болоогүй, иргэний тайланг татварын байгууллагаас урьдчилан бэлтгэж өгөх учир хуулийн зохицуулалтууд нь бүхэлдээ төрийн байгууллагын үүрэгт хамааралтай, иргэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг хялбарчилсан байх тул Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн болон хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзсэн.

--oo00oo--